



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/137

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Төсөв батлах тухай” 2018 оны 20/17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/137 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3.1.21 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” А/137 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд санхүүжих хот тохижилт, нийтийн аж ахуй, барилга засварын ажлын жагсаалтын 19, 20, 21 дүгээр ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зөвлөмжийг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэхийг Үнэлгээний хороо/Т.Хэрлэн/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 03 сарын 20 өдрийн
А/69 тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд	О.Батмөнх	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Э.Уянга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
	Н.Энхбат	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Л.Алтангэрэл	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн